



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/13

Улаанбаатар хот


Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг
түр ашиглуулах гэрээ батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.4 дэх заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түр ашиглуулах гэрээг хавсралт ёсоор баталсугай.


2.Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор төрийн өмчит хуулийн этгээдээс татан төвлөрүүлсэн автомашиныг орон нутагт хүлээлгэн өгөх, шилжүүлэх ажлын хүрээнд "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түр ашиглуулах гэрээ"-г ашиглаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл), аймгийн Орон нутгийн өмчийн газарт даалгасугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
даргын 2023 оны 02 дугаар сарын 02 ны өдрийн
1/13 дугаар тушаалын хавсралт



ТӨРИЙН ӨӨРИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙГ ТҮР АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ

2023 оны ... дугаар
сарын -ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас төрийн өөрийн өмчийн өмчлөгч, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар /цаашид ТӨБЗГ гэх/, түүнийг төлөөлж Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс нөгөө талаас /хуулийн этгээдийн нэр/, түүнийг төлөөлж, /албан тушаал, нэр/, /цаашид Өмч эзэмшигч гэх/, /хуулийн этгээдийн нэр/, түүнийг төлөөлж /албан тушаал, нэр/ /цаашид Өмч ашиглагч гэх/ нар /цаашид хамт нь “Талууд” гэх/ нь дараах нөхцөлөөр харилцан тохиролцож, Иргэний хуулийн холбогдох заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 26, 27 дугаар зүйлийг тус тус үндэслэн байгуулав.

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэхүү гэрээгээр өмч эзэмшигчийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, маркийн улсын дугаартай тээврийн хэрэгслийг /цаашид “эд хөрөнгө” гэх/ **Өмч ашиглагчид ашиглуулахаар шилжүүлэх, Өмч ашиглагч нь хүлээж авсан эд хөрөнгийг албан ажлын зориулалтаар ашиглаж, ашиглалтын зардлыг бүрэн төлөхтэй** холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2.ТӨБЗГ нь эд хөрөнгийг хүлээлцүүлж, акт үйлдэнэ. Актад дор дурдсанаас гадна эд хөрөнгийн санхүүгийн тайлан тэнцлийн үзүүлэлтийг тусгасан байна.

1.2.1 Эд хөрөнгө нь цаашид ашиглаж болох хэвийн нөхцөлд байна.

1.2.2 Эд хөрөнгийг цаашид гэрээнд заасан зориулалтаар ашиглана.

ХОЁР. ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ЭРХ, ҮҮРЭГ

2.1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь эд хөрөнгийг бүртгэлийн дагуу энэхүү өмч ашиглуулах гэрээнд бүрэн тусгаж, хүлээлцэх нөхцөлөөр хангаж, хяналт тавина.

2.2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь өмч ашиглагчаас ашиглалтын төлбөр авахгүй.

2.3.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар Өмч ашиглагчаас ашиглуулах эд хөрөнгийг сайжруулах талаар гаргасан санал, хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

2.4.Эд хөрөнгийг шилжүүлэх шийдвэрийг эрх бүхий дээд байгууллага болон ТӨБЗГ-аас гаргасан тохиолдолд энэ тухай өмч эзэмшигч, өмч ашиглагч талуудад мэдэгдэнэ.

2.5.Өмч ашиглагчийн ашиглаж буй эд хөрөнгийг барьцаалах, түүгээр баталгаа гаргах, ТӨБЗГ-ын зөвшөөрөлгүйгээр дамжуулан эрх залгамжлан ашиглуулахыг хориглоно.

2.6.Эд хөрөнгийг шилжүүлэх шийдвэр баталгаажиж гарснаар ашиглуулах гэрээний хугацаа дуусгавар болсонд тооцно.

ГУРАВ.ӨМЧ ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1.Өмч эзэмшигч нь эд хөрөнгийг өмч ашиглагч байгууллагад хүлээлгэн өгнө.

3.2.Өмч ашиглагчийн гэрээний үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалтын талаар гарсан зөрчлийг арилгуулахаар шаардлага тавих, хохирлыг нэхэмжлэх эрхтэй.

ДӨРӨВ.ӨМЧ АШИГЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1.Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 23-ны 95/260 дугаар хамтарсан тушаалаар баталсан Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журмыг мөрдлөг болгон ажиллана.

4.2.Эд хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, урсгал засвар үйлчилгээ, ашиглалтын зардлыг бүрэн хариуцах бөгөөд ердийн элэгдлээс өөрөөр муутгахгүй байх үүрэг хүлээнэ.

4.3.Эд хөрөнгөд учирсан гэмтэл хохирлыг бүрэн хариуцаж, арилгах үүрэг хүлээнэ.

4.4 Өмч ашиглагч нь Монгол Улсын хууль, холбогдох дүрэм, журам, энэхүү гэрээний заалтыг сахин биелүүлж ажиллана.

ТАВ.ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

5.1.Талууд нь гэрээний үүргийн биелэлтийн хүрээнд харилцан хариуцлага хүлээх бөгөөд нэг тал нь үүргээ биелүүлээгүй бол биелүүлээгүй үүргийн хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

5.2.Ашиглалтын зардлыг хугацаанд эд хөрөнгөд хохирол учирсан тохиолдолд хохирлыг өмч ашиглагч тал бүрэн хариуцна.

ЗУРГАА. БУСАД

6.1.Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь энэхүү гэрээгээр ашиглуулж буй хөрөнгийг хүлээлцэж, ашиглалтад хяналт тавих бөгөөд эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалтын талаар гарсан зөрчлийг арилгуулахаар шаардлага тавих эрхтэй.

6.2.Талууд гэрээнд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлснээр дуусгавар болно.

6.3. Гэрээ нь ... хавсралт, холбогдох бичиг баритын хамт нийт ... (.....) хуудас бөгөөд монгол хэл дээр 3 (гурав) хувь үйлдэж, талууд тус бүр 1 (нэг) хувийг хадгална. Гэрээний эх хувь нь хууль зүйн адил хүчинтэй байна.

6.4.Бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ бусад этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрыг
төлөөлж:

.....
.....

(хэлтсийн дарга,
дарга,
мэргэжилтэн)

Өмч эзэмшигчийг
төлөөлж:

.....
.....

(хуулийн этгээдийн дарга, (хуулийн этгээдийн
нягтлан бодогч)

Өмч ашиглагчийг
төлөөлж:

.....
.....

нягтлан бодогч)

Утас: Утас: Утас:

Мэйл хаяг: Мэйл хаяг: Мэйл хаяг: